

■ ҮЗЭСГЭЛЭН

АВСТРАЛИЙН ХОЛТСОН ДЭЭРХ ЗУРГИЙН ҮЗЭСГЭЛЭН НЭЭГДЛЭЭ

"Эртний мастерууд: Австралийн холтосны агуу зураачид" үзэсгэлэнд Blue Moon арт галерейд энэ сарын 25-нд нээгдлээ. Австралийн соёлын үнэт өвд тооцогддог, Австралийн Үндэсний музейн цуглуулгад багтдаг эдгээр зургаар Австрали олон улсад явуулын үзэсгэлэн гаргасаар иржээ.

Австралийн хойд хэсэгт оршин суудаг Арнхем нутгийн уугуул иргэд хэдэн мянган жил бүтээж ирсэн холтос дээрх зургийг XX зууны сүүлээр дэлхийн урлагийн

агуу уламжлал хэмээн хүлээн зөвшөөрсөн аж. Модны холтос дээр шороогоор зуурсан зосоор зурсан учир эдгээр зургийг газар эхийн бүтээл гэж хэлж болно.

1948 онд Лондон хотын "Таймс" сонинд хэвлүүлсэн нийтлэлд Австралийн Арнхем нутгийн уугуул зураачдыг "эртний мастерууд" гэжээ. Арнхем нутгийн "холтосны зураачид

өнгөрсөн хэдэн арван жилийн хугацаанд дэлхийн урлагийн ертөнц, олон нийтийн анхаарлыг татах болсон. Холтсон дээрх зураачдын дараачийн үе зургийн урлаг, өв соёлоо шинэ чиглэлд баяжуулан, хөгжүүлж байна. Үзэсгэлэнд толилуулж байгаа зургууд нь Арнхем нутгийн гурван найруулгын бүсийг тусгаж байгаа юм. Баруун Арнхем нутагт бэлгэ тэмдгийн дүрс түлхүү байр суурь эзэлдэг. Зүүн Арнхем нутагт геометрийн ба уламжлан тогтсон дүрс ашигладаг бол төв Арнхем нутагт зураачид энэ хоёр арга барилыг хослуулах хандлагатай. Эртний Мастерууд үзэсгэлэн гурван бүсийн холтосон дээрх зургийн томоохон сэдвүүд болох өвөг дээдсийн ертөнц, өөрийгөө хэн гэдгийг илэрхийлсэн байдал, орчин үеийн амьдралын талаарх бодролыг харуулна. Үзэсгэлэн энэ сарын 29-нийг хүртэл үргэлжлэх юм байна.

